

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-12

---

**1.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 4-8

**2.Хоёр.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 8-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
12 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 09 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Б.Батбаатар, П.Наранбаяр, Н.Номтойбаяр, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, Л.Энхнасан.

**Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

**1.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга С.Ган-Очир, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, мөн Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.*

Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийн 2, 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 25 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 34 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
16 цаг 09 минут.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийн мэдээ танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн хүрэлцэн ирсэн байна. Нацагдоржийн Батсүмбэрэл, Энхбатын Болормаа, Хажекберийн Жангабыл, Нанзадын Наранбаатар, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Өлзийхүүгийн Шижир, Жадамбын Энхбаяр, Дашцэрэнгийн Энхтүвшин, Сүхбаатар, Эрдэнэболд, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр хэлэлцэх асуудал хоёр асуудал байгаад байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг байгаа. Манай Байнгын хорооноос санал, дүгнэлтээ гаргаад Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхээр байна.

Хоёрдугаарх нь “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Мөн 12 сарын 25-ны өдөр Засгийн газрын өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ манай Байнгын хороо бас мөн Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлц хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэгдүгээр асуудал. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ажлын хэсгийг оруулаарай. Учрал сайдыг бас дуудъя. Учрал сайдыг иртэл ажлын хэсгийг танилцуулж байя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Дорждэрэмийн Цолмон, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Бат-Эрдэнийн Хулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Алтангэрэлийн Мандуул, Эдийн засаг,

хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн ирж байх шиг байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Бодлогын газрын дарга Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн. Уранчимэг дарга ирээгүй байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Чимэдсүрэн дарга, Усны газрын дарга Зэнээмядарийн Батбаяр дарга байна. Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Энхгэрэлийн Нямдаваа. Өөр? Ингээд болж байх шиг байна тээ. Физикийн ухааны доктор Норовын Тэгшбаяр, “Мон-Атом” компанийн ахлах геологич Амарсанаагийн Алтанхундага гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан нэгийн тухай хуулийн дагуу 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гээд заасан байгаа.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Байвал нэрсийг авъя.

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад гишүүдээс гаргасан санал байхгүй байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Үндэсний баялгийн сан тэр 3 төрөл дээр хуваагдаж байгаа шүү дээ тэр чинь тийм ээ. Яах вэ энэ ойлгомжтой. Ер нь үндэсний баялаг гээд ярихаар Монгол хүн, Монгол компани байж таарна л даа хамгийн нэгдүгээрт. Тэгээд би энэ хараад байгаа энэ манай энэ хувийн хэвшлүүдийг яасан их ад үздэг юм бэ энэ Засгийн газар нь байгаа юу? Тухайлбал, энэ бусад компаниуд “Samsung” энэ тэр Солонгосын бахархал байдаг шүү дээ. Улс орныг өөд нь татсан энэ чинь хувийн компаниуд л татдаг байхгүй юу. Тэр Фордыг хар Америкийн. Тесла байна. Одоо Хятадад “Шяоми”, “Би Вай Ди” гээд л ийм компаниуд байна. Жишээ татъя л даа. Тэр хувийн хэвшил анх төмөр зам барьж байсан. Тэрийг нь тэр чигээр нь бариулчихсан байсан бол Монгол Улс өнөөдрийн хөгжил нь ямар байх байна вэ?

Хоёрдугаарт энэ Эрдэнэтийн 49, Монголросцветмет-ийн 49 хувийг авчирсан компани байгаа. Монгол компани. Бүгдээрээ л эд нар Монгол хүмүүсийг ажилд авч, татвар төлж, баялаг бүтээж ингэдэг компаниуд. Гэтэл яаж байна? Байнга ад үзэгдэнэ. Энэ 49-ийг авчирсан хүмүүс эх орончид гэж бодож байна би. Ер нь энэ улсууд нь ингээд л байнга хохироод явж байдаг. Үгүй энэ Монгол Улсад чинь ямар компани, ямар хүн ажиллах юм.

Тэгээд гадна, дотнын компанийн захидлын бариад л гүйж байдаг энэ Засгийн газрын сайд нар нь, ер нь энэ хохирсон, алдагдсан боломжийг ер нь яаж

төлж байгаа, яаж энэ монгол компаниудыг хаалга үүдээ барьдаг, энэ олон хүмүүс зугтаж гарч байгаа энэ бүх юм чинь баялгийг нь нэг газар хураагаад л аваад байдаг. Яг ийм авлигажисан Монгол Улсад энэ Баялгийн сан чинь ажиллах юм уу? Энэ компаниуд чинь өдөр өдрөөр ингээд хэцүүдэж байна. Эд нарыг яах юм? Энийг, Учрал сайдад хэлэхэд таны тэр хийсэн гавьяа энэ хүнийг бас одонгоор шагначихад зүгээр байх. Тэр Орано дээр нь. Энэ талаар та анхаарч арай дээр юм шиг байгаа юм Засгийн газартаа. Бусад нь ч мэдэхгүй. Хариултыг чинь сонсьё.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. 3 номер, Учрал сайд.

**Н.Учрал:** Ер нь энэ Үндэсний баялгийн сангийн хууль яг хэрэгжээд сая 4 сараас хойш яг өдий хүртэл гэхээр чинь 7, 8 сарын хугацаанд 480 тэрбум төгрөгийг төрийн өмчийн уул уурхайн 5 компани бүрдүүлсэн. Тэгээд үүнийг нь яг иргэн болгонд хуваагаад үзэхээр 135 мянган төгрөг буюу ийм хадгаламж үүсэж байгаа юм.

Цаашдаа энэ стратегийн орд эзэмшиж байгаа компаниудыг ч гэсэн ер нь хэлэлцээрт ороод энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааны менежментэд орохоосоо татгалзъя л гэж байгаа юм. Чадахгүй байж оролцдог, тэгээд санхүүгийн хариуцлага хүлээдэг, хөрөнгө оруулалт хийдэггүй, ажлыг нь явуулдаггүй. Ийм байсны оронд төр 34 хувийнхаа ноогдол ашгийг авч байвал тусгай АМНАТ-аар бүтээгдэхүүн хуваахаар оруулдаг энэ эрх зүйн орчныг нь нээчихвэл цаашдаа хэлэлцээр хийх яг энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу жишгээр явах зөв тогтолцоо бүрдэнэ.

Тэгээд цаашдаа хувийн хэвшил татвараа төлөөд, улсдаа төлбөрөө төлөөд явж л байвал үйл ажиллагаанд төр их оролцох гээд байдгаасаа татгалзах нь зөв. Энэ утгаараа бол энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээ бол цаашдаа энэ Баялгийн сангийн хуулийг амилуулахад хувийн хэвшилтэй хэлэлцээрэй гэхэд хувийн хэвшлийг дэмжсэн бодитой ажил болно.

Тэгээд ирэх жилийн өдийд гэхэд бид нар эд нар И-Монгол дээр харагдаад байгаа иргэн таны хуримтлалын дансанд байгаа 135 мянга өссөн үү, өссөн бол аль уул уурхайн компаниас хэдэн төгрөгийн ноогдол ашиг орсон бэ гэдгийг хардаг болох ийм эрх зүйн орчин бүрдүүлье гэдэг зорилгоор энэ Үндэсний баялгийн сангийн хууль дээр хэрвээ тэр төрийн эзэмшлийн 34 хувь хүртэлх хувийг АМНАТ-аар орлуулаад авах юм бол орлуулсан тэр бүх хэлбэр нь хуримтлалын сан буюу иргэдийн хуримтлал руу ордог болох энэ эрх зүйн орчныг л нээж байгаа юм.

Ингэснээрээ бид нар цаашдаа иргэн та байгалийнхаа баялагт эзэн болох, цаашлаад ер нь бид нар ТУЗ-д 2, 3 хүн суулгаснаараа үр дүнд хүрэхгүй гэдгийг харж байгаа шүү дээ. Жишээ нь, энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээн дээр бол тэр хүн ТУЗ-д 1 хүн суугаад тэр 10 хувийг төлөөлөх ч гэсэн тэр вето эрхтэй гэдэг чинь Засгийн газар хориг тавих бололцоотой байна гэдэг чинь маш том эрх байхгүй юу.

Гэтэл Оюу толгой дээр өнөөдөр 34 хувийн хувийг төлөөлж байгаа ТУЗ-д сууж байгаа тэр 2 биз дээ тээ. Тийм 3. Тэр 3 ТУЗ-ийн гишүүн чинь өнөөдөр хориг ч тавих ч эрхгүй шүү дээ. 3 хүнийг цалинжуулж байгаа болохоос өөр ямар үр дүн байгаа юм? Тэгэхээр 1 хүн хориг тавих эрхтэй оролцоно гэдэг хамаагүй том боломж. Тэгэхээр энэ бол хувийн хэвшлийг дэмжсэн хөрөнгө оруулалтын гэрээ, хувийн хэвшлийг дэмжсэн ийм хэлэлцээр. Цаашдаа бид нар ер нь хувийн

хэвшилтэйгээ ерөөсөө л ийм “win win” гэдэг зарчмаар л хэлэлцээр хийж явж байж Баялгийн сан хуримтлал нь өснө. Тэгэхээр Ганбат гишүүний энэ саналыг дэмжиж байна.

**Г.Тэмүүлэн:** 2 дугаар зүйлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2 дугаар зүйл дээр холбогдуулж гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Мөн бичгээр ирүүлсэн санал байхгүй байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гишүүдэд цаасаар тараагдсан байгаа. Байнгын хорооны групп дээр бас цахимаар бас тавигдчихсан байгаад байгаа хуулийн төслүүд. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя.

Алга байна.

Мөн бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулж бичгээр ирүүлсэн санал бас алга байна.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

3 дээр алга байна.

Бичгээр ирүүлсэн санал бас байхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Бичгээр ирүүлсэн санал бас алга байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар байгаа. Манай Байнгын хорооноос Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Жаргалан гишүүн байгаа байх тээ? Тийм Жаргалан гишүүн танилцуулъя. Хоёр дахь асуудалдаа орцгооё.

16.22 цаг

**“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа албан тушаалтнууд мөн адил түрүүн танилцуулсан байгаа.

Хууль санаачлагч тогтоолын төслийн талаар тодруулга, тайлбар хийж болно шаардлагатай бол.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя.

Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Би тэр Орано дээрээ нэлээн урьдынхаа алдаа, дутагдлаас суралцсан тийм үлгэр жишээ гэрээ болох төлөв рүүгээ явж байгаа гэж ойлгож байгаа. Энэ ондоо багтаад тэрийгээ хийчхээсэй ч гэж бодож байна.

Нөгөө талаар анхаарах зүйл бол нэгэнт стратегийн орд учраас тэр бүтээгдэхүүн хуваах тэр юмныхаа 50 хувийг, ураныхаа 50 хувийг өөрөө мэдэж оролцдог байх. Энэ дээр анхаараарай. Үнэхээр тэргүүний техник, технологи хэрэглэдэг ийм компани мэдээж байгаа байх. Түүгээр нь баталгааг нь гаргуулаарай гэсэн ийм санал байгаа юм.

Энэ далимд тэр түрүүн би хэд хэдэн компаниудыг ярилаа. Жишээлбэл, “Цагаан суварга” МАК. Энэ компани бас үндэсний баялаг. Монгол хүмүүсийг ажиллуулж, баялаг бүтээгээд ингээд явж байгаа. Бас Эрдэнэтийн 49 хувь. Би түрүүн хэллээ тэд нар чинь эх орончид байхгүй юу. Тэр 49 хувийг нь Эрдэнэтийн болон Монголросцветмет-ийн 49 хувийг нь авъя гэсэн гадна, дотнын зөндөө хүмүүс байгаа байх. Тэгэхэд өгөхгүй л байлгаад байна шүү дээ зайлуул.

Тэгэхээр ийм мэтчилний стратегийн орд гэж нэрлээд байгаа энэ зүйлүүдээ ер нь та нар яг яаж шийдэх юм бэ? Энэ монгол хүн, монгол компани яг энэ бид нар 92 онд тэр хувийн өмч, тэр ардчилсан нийгэм энэ тэрийг сонгочихсон гэж ойлгож

байгаа. Өнөөдөр энэ дээр яг энэ баруун төвийн үзэл баримтлалтай намын хүн нь ярих ёстой гэж ойлгоод байгаа. Хэн ч ярихгүй байгаа байхгүй юу. Цөөхөн ярьж байна. Энийг юу гэж бодож байна? Яаж шийдээд байна?

Тэгээд гаднын компанийн юмыг бариад л гүйгээд байх юм энэ Засгийн газар. Бид нар тэгээд яачихсан улсууд юм? Энэ Монголын ард түмний заяа нь энэ юм уу, хаашаа юм? Бид нар хүн шиг амьдарч болохгүй юу? Улс шиг улс оронд. Энэ Засгийн газар яг ямар хүмүүсийн төлөө ажилладаг юм бэ? Монгол Улсын Засгийн газар гэсэн нэртэй л байх шиг байх юм. Гоё Пи Ар, үлгэр ярих энэ тэр төгсөрчихсэн шүү дээ. Одоо яах вэ дээ тэгээд бид нар харанхуйд шинэ жилээ, тэгээд л тэр үлгэрийг тэгээд л давтан яриад л.

Тэгээд бүх ард түмэн уранхай хувцастай, туранхай царайтай, 30 хувь нь ядуу, энэ бусад улс орны хүмүүс яаж баяжиж байгаа, дарга нарын ямар тарган цатгалан байгаа тухай яриад л, удахгүй бид нар тийм болж магадгүй гээд л найдаад л.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу тээ? Ганбат гишүүний асуултад хариулъя. 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Ер нь яах вэ өнгөрсөн парламент Ганбат гишүүн бид энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг баталсан л даа. Тэгээд тэр Баялгийн сангийн хууль дээр ч гэсэн тухайн үед гишүүд их олон санал хэлж байсан. Ялангуяа тэр төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд, тэр дундаа стратегийн орд эзэмшиж байгаа компаниудынхаа 34 хүртэлх тэр хувийг нь төр үнэ төлбөргүйгээр авна гэдэг ийм заалттай. Тэгээд Баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын ийм тогтоол гарсан.

Энэ бол ямар тогтоол юм бэ гэхээр шууд тэр 34 хувийг нь авъя ч гэдэг юм уу ингэж шийдэж болохгүй л дээ. Тэр хэлэлцээр хийх ёстой. Тэгэхээр хэлэлцээр хийх гэхээр ингээд эрх зүйн орчин ийм хаалттай байгаад байсан. Тийм учраас энэ гэрээний үеэр бид нар энэ Ашигт малтмалын хууль, Баялгийн сангийн хуулиа нэг мөр нэг талд нь гаргая.

Цаашдаа ерөөсөө л хувийн хэвшилтэйгээ кэйс болгон дээрээ тус тусдаа хэлэлцээр хийе. Тэр Цагаан суваргын орд гээд л тэглээ олон жил ярилаа. Үгүй тэгээд л хоёр талдаа суугаад л хуулийнхаа дагуу хэлэлцээрийг л хийе л дээ. 34 хүртэлх ашгаа төр ямар нэгэн байдлаар авах, дээрээс нь Монголын ард түмэн газрынхаа хэвлийн баялагт 50 дээр нэмэх нэгийг эзэмших ёстой гэдгээ хангуулж л байвал ямар өр төлбөр, татвар хураамжийг авбал тэр 50 дээр нэмэх нэг хүрэх юм, нөгөө хөрөнгө оруулагч талын яг үр өгөөж нь хэд байх юм, юу юу байх юм, Засгийн газрын үр өгөөж нь юу байх юм бэ гээд л хэлэлцээр хийгээд л нэг талдаа гаргаад л, тэрийгээ Их Хуралд орж танилцуулаад л, шаардлагатай бол АМНАТ-аар орлуулах бүтээгдэхүүн хуваахаар орлуулах тогтоол гаргаад л ингээд шийдчихвэл хувийн хэвшил аль нэг Засгийн газар гарч ирснээс болоод үйл ажиллагаа нь саатах ийм байдал байхгүй болчихно шүү дээ. Их Хурлаар байгуулагдсан гэрээтэй болчихвол тогтвортой үйл ажиллагаа явуулаг. Бүх л энэ компаниудтай ийм хэлэлцээр хийх л хэрэгтэй.

Одоо тэр Эрдэнэтийн 49 дээр ч гэсэн одоо ингээд л бас маргаан үргэлжилж л байна. Эрдэнэт жишээ нь улсын төсөвт үйлдвэрийн газар гээд л статустай яваад байдаг. Бид нар энэ 1 сард бол энэ төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн

компанийн засаглалыг маш ойлгомжтой болгох ёстой. Тэгж байж энийг шийдэхгүй бол ингээд улсын төсөвт үйлдвэрийн газар гээд ТУЗ-гүй яваад байж болох юм уу, болохгүй юм уу? Тэгэхээр энийгээ тэр 49-ийн маргаан ч байна уу, энийг нэг талд нь гаргая. Тийм учраас энэ олон жил яригдсан асуудлуудаа нэг талд нь гаргая гэдэг утгаараа. Ер нь бол энэ чуулгандаа багтаагаад бид нар бол Оюу толгойн татварын маргаанаа ч гэсэн талдаа гаргана. Тэр Петро Чайнагийн асуудлыг ч гэсэн ингээд шийдээд явъя. Энэ 49-ийн маргааныг ч гэсэн шийдье. Тэрнээс ингээд байгаад байвал хэн нэгэн энийг барьж аваад шийдэхгүй юм байна лээ л дээ.

Тэгэхээр зориг гаргаад ингээд шийдээд явах нь энэ хамтарсан Засгийн газрын ажил. Тэгээд цаашаа гол нь иргэд хожиж л байх ёстой, 50 дээр нэмэх нэгийг хангуулж л байх ёстой л гэдэг зарчим болохоос биш ашгаа авна уу, АМНАТ-аар орлуулна уу, газрын хэвлийн баялгаа яаж хүртэнэ вэ энэ бол тэр чинь төрийн үйл ажиллагааны л менежментээс шалтгаална шүү дээ. Тэгэхээр би бас энэ асуудал дээр Засгийн газар бас анхаарч ажиллаж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүн нэмж тодруулъя.

**Д.Ганбат:** Статус нь тодорхойгүй компаниуд олон байна л даа. Стратегийн орд, байгалийн баялаг эзэмшигч ийм компаниудыг ингээд харж байхад тухайлбал, Эрдэнэс Тавантолгой байна. Энэ яг компани уу, хувьцаат компани уу? Хэрвээ тийм юм бол яагаад ТУЗ нь байдаг юм шиг байгаа юм. Би хувьцаа эзэмшигч нь юм бол яагаад би хуралд суудаггүй юм? Компанийн хууль байгаа шүү дээ. Тэр ноогдол ашиг энэ тэрээ хуваарилах, тайлан, балансаа танилцуулах энэ тэр гээд бүх юмыг нь явдаг. Баялгийн сан гээд баахан юм тэндээ овоолж авчирчхаад тэн дээрээ болохоор хэдэн дарга нар мэдээд ямар ч хуульгүй шийдвэр гаргаад байдаг. Энэ хуулийг чинь хэн биелүүлэх ёстой юм? Уул нь Засгийн газраас эхлээд л Улсын Их Хурал нь шахаж шаардаад Засгийн газар нь хэрэгжүүлээд явах ёстой. Ийм л ёстой шүү дээ. Тэр засаглал хуваах зарчмаараа ч гэсэн. Тэгээд ийм ойлгомжгүй байдлууд их олон байна. Үүнийгээ цэгцлээч. Хэдий хугацаанд цэгцэлчхэв? Боломжтой юу, боломжгүй юу? Бид нар л баахан энд хууль яриад байдаг. Тэр хуулийг чинь биелүүлдэг тэр Засгийн газар чинь тийм юм алга л байна шүү дээ. Тэр манлайлал үзүүлж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Санал гэж ойлголоо. Тийм тэлье Учрал гишүүн нэмээд хариулъя. 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** OECD-гийн тэр зөвлөмж өгсөн. Ер нь бол төрийн өмчийн компанийн дуу, компаниудын бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх тухай эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Засгийн газраас он гараад 1 дүгээр сарын 10-ны дотор Их Хуралд өргөн мэдүүлнэ. Энэ хуулиар бол бид нар энэ статусыг маш ойлгомжтой болгоно. Тэгээд энд бол төрийн өмчийн компаниудын 40 хувь ер нь цомхотгогдоно гэсэн үг. Нэгтгэж нийлүүлнэ, татан буулгана, хөрөнгө босгох чиглэлээр нээлттэй компани болгохыг нь болгоно.

Эрдэнэс Тавантолгойн хувьд нөгөө 1072 хувьцааг иргэд эзэмшдэг хувьцаат компани. Гэтэл бол одоо тэр хадгаламжийн корпорац дээр л энэ листэд болсон болгож бирж дээр гараагүй. Бирж дээр гаргаад эхэлье гэхээр яг тэр нөгөө сайн хувьцаа гэдэг шиг иргэд санхүүгийн зах зээлийн мэдлэггүйгээсээ болоод нөгөө хувьцаагаа зардаг, үрдэг. Ингээд дараа нь ноогдол ашиг тараах гэхээр миний хувьцаа хааччихсан бэ гэдэг асуудалд орно.

Тийм учраас сая Засгийн газраас шийдвэр гаргаад энэ хөрөнгийн зах зээл, санхүүгийн зах зээлийн ойлголтыг үндэсний хэмжээнд сайн өгч байж хэвшүүлж байж энэ 1072-ыг энгийн хувьцаанд шилжүүлж зардаг, үрдэг болгохгүй бол өнөөдөр шууд ингээд бирж дээр гаргаад тавьчихаар энэ 26 хувийг эзэмшиж байгаа энэ иргэд чинь хувьцаагаа зарж үрээд тэгээд сая Тавантолгойн ноогдол ашгаас эхний үе шатыг бол эхлүүлээд ингээд хувьцаа эзэмшигчийн хувьд шийдвэр гаргаад, ТУЗ шийдээд 121 мянган төгрөг ингээд тараасан шүү дээ. Энэ ноогдол ашиг. Хувьцаа эзэмшигчдээ авах л ёстой зүйл байхгүй юу. Тэрнээс биш энэ бол нөгөө Баялгийн санд ороод байгаа биш. 1072 хувьцаа эзэмшигчдийн авах ёстой зүйл. Тэгэхээр он гараад бараг 400 орчим мянган төгрөг тараах болж байна шүү дээ. Тэгээд үүнээс 121 мянгыг нь эхлээд хувьцаа эзэмшигч нарт хүртээсэн. Одоо ингээд цаашаа 2, 3 хуваагаад явна.

Ер нь ингээд сая энэ хил холболтын төмөр замын ажил явбал мэдээж цаашдаа энэ Тавантолгойн ноогдол ашиг иргэд хүртэх нь өснө л гэж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Сая “Стратеги ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” тогтоолын 1 дүгээр зүйл, заалтаар асуулт асууж, хариулт авлаа.

Бичгээр ирүүлсэн санал алга байна.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Бичгээр ирүүлсэн санал алга байна.

Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Бичгээр ирүүлсэн санал алга байна.

Ингээд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Мөн Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар байгаад байгаа. Жаргалан гишүүнийг танилцуулахаар томилъё.

Асуудлыг хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын ажлын хэсгийнхэнд баярлалаа. Мөн өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооныхоо гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

16.34 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*